



**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ,  
ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН  
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА  
ЭРХЛЭГЧДИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ  
ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГИЙН  
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

*Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газар*



# АГУУЛГА

**1**

**САЛБАРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

**2**

**БОРЛУУЛАЛТЫН ТОЙМ**

**3**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
ҮЗҮҮЛЭЛТ**

**4**

**ДҮГНЭЛТ**



## Товчилсон үгийн тайлал

1. Хороо-Санхүүгийн зохицуулах хороо
2. ҮМҮЧЭТХЭАЭ-Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч



## Хүснэгт, дүрслэлийн жагсаалт

- Хүснэгт 1. ҮМҮЧЭТХЭАЭ байриллаар*  
*Хүснэгт 2. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт*  
*Хүснэгт 3. Орлого, үр дүнгийн тайлангийн үзүүлэлт*

- 
- Дүрслэл 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдүүдийн тоо*  
*Дүрслэл 2. ХЭ, ХНХ, оноосон нэр, салбар нээх хүсэлтүүдийн шийдвэрлэлт*  
*Дүрслэл 3. ҮМҮЧ-ны арилжаа эрхлэгч иргэд байриллаар*  
*Дүрслэл 4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (мянган төгрөгөөр)*  
*Дүрслэл 5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц*  
*Дүрслэл 6. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц*  
*Дүрслэл 7. Худалдан авсан болон худалдсан үнэт металлын хэмжээ*  
*Дүрслэл 8. Худалдан авсан болон худалдсан алтны хэмжээ*  
*Дүрслэл 9. Худалдан авсан болон худалдсан мөнгөний хэмжээ*



## Хураангуй

### **Бүртгэл, зөвшөөрлийн чиглэлд:**

Тайлант хугацааны байдлаар нэр бүхий 49 хуулийн этгээд, 461 иргэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 2-оор, иргэдийн тоо 7-оор нэмэгдсэн байна.

Тусгай зөвшөөрөлтэй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдүүдээс хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, салбар нээн ажиллуулах, эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийн тухай нийт 7 хүсэлт Хороонд ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, 6 хүсэлтийг шийдвэрлэсэн.

### **Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид:**

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 494.8 кг үнэт металлыг 63,850,584,332.3 мянган төгрөгөөр худалдан авч, 576.1 кг үнэт металлыг 75,503,792,409.9 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь 2022 оны эхний хагас жилтэй харьцуулбал худалдан авсан үнэт металлын хэмжээ 1.6 дахин, худалдсан үнэт металлын хэмжээ 1.4 дахин буурсан үзүүлэлт юм.

ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид тайлант хугацаанд 454.4 кг алтыг 63,807,874.3 мянган төгрөгөөр худалдан авч, 539.7 кг алтыг 75,354,440.0 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан алтны хэмжээ 1.5 дахин, худалдан борлуулсан алтны хэмжээ 1.4 дахин буурсан байна.

Мөн ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид тайлант хугацаанд 40.4 кг мөнгийг 141,710.0 мянган төгрөгөөр худалдан авч, 36.4 кг мөнгийг 149,352.4 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 2.4 дахин, худалдан борлуулсан мөнгөний хэмжээ 1 дахин бууржээ.

### **Хяналт шалгалт:**

Тайлант хугацаанд 648 борлуулалтын мэдээ, 49 хуулийн этгээдийн санхүүгийн тайланг хянан баталгаажуулж, салбарын нэгтгэлд хамруулав.


Хорооны 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 11/2011 тоот албан бичгээр нэр бүхий 211 үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэдэд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай мэдэгдлийг хүргүүлсэн.

Хорооны 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар нэр бүхий 106 иргэний үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, нэр бүхий 8 иргэний дээрх төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.



## 2023 оны эхний хагас жилийн тайлангийн нэгтгэл

Тайлант хугацааны байдлаар нэр бүхий 49 хуулийн этгээд, 461 иргэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 2-оор, иргэдийн тоо 7-оор нэмэгдсэн байна. Зохицуулалттай этгээдүүдийг тоог өмнөх оны мөн үетэй харьцуулан дүрслэл 1-д үзүүлэв.



Хуулийн этгээд

Иргэн

Дүрслэл 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдүүдийн тоо

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдүүдээс хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, салбар нээн ажиллуулах, эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийн тухай нийт 7 хүсэлт Хороонд ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, 6 хүсэлтийг шийдвэрлэсэн. Эдгээр хүсэлтийг төрлөөр нь ангилан дүрслэл 2-т үзүүлэв.



1

ХНХ, ХЭ

5

Салбар

1

ЭБАТ

Дүрслэл 2. ХЭ, ХНХ, оноосон нэр, салбар нээх хүсэлтүүдийн шийдвэрлэлт

106

Түдгэлзүүлсэн

8

Хүчингүй болгосон

Хорооноос 2023 оны эхний хагас жилийн байдлаар нэр бүхий 8 иргэний үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нэр бүхий 106 иргэний тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн.



## 2023 оны эхний хагас жилийн тайлангийн нэгтгэл

Тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгчдийн 79.6 хувь буюу 367 иргэн Улаанбаатар хотод, 20.6 хувь буюу 94 иргэн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд байршлаар нь ангилан хүснэгт 1-д үзүүлэв.

Дүүрэг	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулууны, арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд
Сүхбаатар	5	8	6	12
Хан-Уул	0	9	3	12
Баянзүрх	4	7	11	3
Чингэлтэй	40	188	36	15
Баянгол	9	19	3	4
Сонгинохайрхан	6	12	1	2
Орон нутаг	6	8	79	1

Хүснэгт 1. ҮМҮЧЭТХЭАЭ байршлаар

Орон нутагт үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхэлж буй нэр бүхий 79 иргэнийг байршлаар нь ангилан дүрслэл 3-д үзүүлэв.

Сэлэнгэ	21	Говь-Алтай	3
Баянхонгор	15	Увс	2
Төв	14	Дорноговь	1
Дархан-Уул	11	Өвөрхангай	1
Өмнөговь	6	Дорнод	1
Ховд	4		

Дүрслэл 3. ҮМҮЧ-ны арилжаа эрхлэгч иргэд байршлаар

Харин үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн хувьд Өмнөговь аймагт 2, Говь-Алтай аймагт 2, Дархан-Уул, Хэнтий, Увс аймгуудад тус тус 1 иргэн үйл ажиллагаа эрхэлж байна.


Мөн үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 5 иргэн Дархан-Уул аймагт, 2 иргэн Ховд аймагт, 1 иргэн Баянхонгор аймагт тус тус үйл ажиллагаа эрхэлж байна.



# 2023 оны эхний хагас жилийн тайлангийн нэгтгэл

## Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгө


Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ 49 хуулийн этгээд нь 78 хувьцаа эзэмшигчийн 9,554,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчдийн тоо 5.4 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




Дүрслэл 4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (мянган төгрөгөөр)

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 49 хуулийн этгээдийн 9,554,419.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 57.8 хувийг дотоодын хөрөнгө оруулалт, 42.2 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.

Тайлант хугацаанд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтын эзэлж буй хувийг дүрслэл 5-д үзүүлэв.




### 2023.И



Дүрслэл 5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

Тусгай зөвшөөрөлтэй 49 хуулийн этгээдийн 31 нь 1 хувьцаа эзэмшигчтэй, 13 нь 2 хувьцаа эзэмшигчтэй, 5 нь 3 буюу түүнээс дээш хувьцаа эзэмшигчтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдийг хувьцаа эзэмшигчдийн тоогоор нь ангилан дүрслэл 6-д үзүүлэв.



Дүрслэл 6. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



## 2023 оны эхний хагас жилийн тайлангийн нэгтгэл


### Борлуулалтын тойм

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 494.8 кг үнэт металлыг 63,850,584,332.3 мянган төгрөгөөр худалдан авч, 576.1 кг үнэт металлыг 75,503,792,409.9 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь 2022 оны хагас жилтэй харьцуулбал худалдан авсан үнэт металлын хэмжээ 1.6 дахин буурч, мөн худалдсан үнэт металлын хэмжээ 1.4 дахин буурсан үзүүлэлт юм.




Дүрслэл 7. Худалдан авсан болон худалдсан үнэт металлын хэмжээ

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь тайлант хугацаанд 454.4 кг алтыг 63,807,874.3 мянган төгрөгөөр худалдан авч, 539.7 кг алтыг 75,354,440.0 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан алтны хэмжээ 1.5 дахин буурч, худалдан борлуулсан алтны хэмжээ 1.4 дахин буурсан байна.



Дүрслэл 8. Худалдан авсан болон худалдсан алтны хэмжээ

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь нийт 40.4 кг мөнгийг 141,710.0 мянган төгрөгөөр худалдан авч, 36.4 кг мөнгийг 149,352.4 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 2.4 дахин буурч, худалдан борлуулсан мөнгөний хэмжээ 1 дахин буурсан үзүүлэлттэй байна.



Дүрслэл 9. Худалдан авсан болон худалдсан мөнгөний хэмжээ





## Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

**2022.II**

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 44 хуулийн этгээд нэгтгэлд хамрагдсан бөгөөд нийт 74 хувьцаа эзэмшигчийн 9,334,419.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө, 24,522,612.6 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Эргэлтийн хөрөнгө

82%

Эргэлтийн бус хөрөнгө

18%

Эздийн өмч

14%

Өр төлбөрийн хэмжээ

86%

**2023.II он**

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэгчдийн 2023 оны эхний хагас жилийн тайлангийн нэгтгэлд 49 хуулийн этгээд хамрагдсан бөгөөд 78 хувьцаа эзэмшигчдийн 9,554,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 55,728,797.3 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Эргэлтийн хөрөнгө

81.7%

Эргэлтийн бус хөрөнгө

18.3%

Эздийн өмч

43.9%

Өр төлбөрийн хэмжээ

56.1%

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, нийт хөрөнгө, хуримтлагдсан ашиг, өр төлбөрийн нийт дүнд дараах байдлаар өөрчлөлт орсон байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ

1

дахин өсөв.

Нийт хөрөнгийн дүн

2.3

дахин өсөв.

Хуримтлагдсан ашгийн хэмжээ

2.8

дахин өсөв.

Өр төлбөрийн нийт дүн

1.5

дахин өсөв.



## Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

2022.II

2023.II

### Нийт орлого

4,247,940.6 мянган төгрөг

### Борлуулалтын орлого

3,979,185.9 мянган төгрөг

### Нийт зардал

7,284,946.6 мянган төгрөг

Цэвэр ашиг **-3,037,005.7**

мянган төгрөг

### Нийт орлого

28,773,033.5 мянган төгрөг

### Борлуулалтын орлого

28,898,798.6 мянган төгрөг

### Нийт зардал

23,433,903.1 мянган төгрөг

Цэвэр ашиг **5,339,130.4**

мянган төгрөг

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүд 5,339,130.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2.8 дахин өссөн үзүүлэлт юм.

Мөн үед зохицуулалттай этгээдүүдийн нийт зардлын хэмжээ 23,433,903.1 мянган төгрөг байсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.2 дахин өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 2. Орлого, үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2022.II	2023.II	Зөрүү
Нийт орлого	100%	100%	-
Борлуулалтын орлого (цэвэр)	93.7%	98.4%	4.7%
Бусад орлого	6.3%	1.6%	-4.7%
Нийт зардал	100%	100%	-
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	19.8%	66.5%	46.7%
Борлуулалт, маркетингийн зардал	5.2%	14.5%	9.3%
Ерөнхий ба удирдлагын зардал	73.0%	13.8%	-59.2%
Санхүүгийн зардал	1.2%	1.7%	0.5%
Бусад зардал	-	0.6%	0.6%
Татварын зардал	0.7%	2.4%	1.7%
Бусад гарз	0.1%	0.5%	0.4%
Тайлант үеийн цэвэр ашиг	(3,037,005.7)	5,339,130.4	-



## Бодлого, зохицуулалтын орчин



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН ЯАМ

Хорооны 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 233 дугаар тогтоолоор “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг шинэчлэн баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны актын бүртгэлд бүртгүүлэв.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах зорилгоор 2023 оны 4 дүгээр сарын 13-16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Mongolian jewellery and metal-2023” арга хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ҮМҮЧЭТХЭА-ийн зохицуулалт, хууль, эрх зүйн орчны талаарх зөвлөгөө, мэдээллийг 500 орчим иргэн, хуулийн этгээдэд хүргэж ажиллав.



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагын зөвлөмж болон хууль эрх зүйн орчин, хяналт шалгалтын талаарх мэдээлэл хүргэх зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, арилжаа эрхлэгчид зэрэг 60 орчим хүнийг хамруулсан хэлэлцүүлгийг 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулав.

Стандарт, хэмжил зүйн газраас ирүүлсэн баталгаажуулалтын байгууллагаас олгосон тохирлын гэрчилгээг үндэслэн зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулж болох бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтын төсөлд санал хүргүүлэв.



## Сургалт



Нэр бүхий 211 ҮМҮЧЭТХЭА иргэнд дээрх төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай мэдэгдлийг хүргүүлэх ажлын хүрээнд 4 удаагийн сургалтыг зохион байгуулж, 80 иргэнийг хамруулав.

## Хурал, уулзалт

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр нэр бүхий 4 төрийн байгууллага, (Монголбанк, Эрүүгийн цагдаагийн алба, Экологийн цагдаагийн алба, Ашигт малтмал, газрын тосны газар) 3 мэргэжлийн холбоодын төлөөллүүдтэй 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдөр хамтарсан уулзалтыг зохион байгуулав.



Тайлант хугацаанд Хороонд 49 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээд, 461 ҮМҮЧЭТХЭАЭ иргэн бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 2-оор, иргэдийн тоо 7-оор нэмэгдсэн байна

Хорооноос 2023 оны эхний хагас жилийн байдлаар нэр бүхий 8 иргэний үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нэр бүхий 106 иргэний тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлжээ.

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ 49 хуулийн этгээд нь 78 хувьцаа эзэмшигчийн 9,554,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчдийн тоо 5.4 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2.4 хувиар өссөн үзүүлэлт юм.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 49 хуулийн этгээдийн 9,554,419.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 57.8 хувийг дотоодын хөрөнгө оруулалт, 42.2 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 494.8 кг үнэт металлыг 63,850,584.3 мянган төгрөгөөр худалдан авч, 576.1 кг үнэт металлыг 75,503,792.4 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь 2022 оны хагас жилтэй харьцуулбал худалдан авсан үнэт металлын хэмжээ 1.6 дахин, худалдсан үнэт металлын хэмжээ 1.4 дахин буурсан үзүүлэлт юм.

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь тайлант хугацаанд 454.4 кг алтыг 63,807,874.3 мянган төгрөгөөр худалдан авч, 539.7 кг алтыг 75,354,440.0 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан алтны хэмжээ 1.5 дахин, худалдан борлуулсан алтны хэмжээ 1.4 дахин буурсан үзүүлэлт юм.

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь нийт 40.4 кг мөнгийг 141,710.0 мянган төгрөгөөр худалдан авч, 36.4 кг мөнгийг 149,352.4 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 2.4 дахин, худалдан борлуулсан мөнгөний хэмжээ 1 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд 49 ҮМҮЧЭТХЭА хуулийн этгээдүүдийн нийт хөрөнгийн дүн 55,728,797.3 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 дахин өссөн үзүүлэлттэй байна. Нийт хөрөнгийн 81.7 хувийг эргэлтийн хөрөнгө, 18.3 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол өр төлбөр ба эздийн өмчийн дүнгийн 43.9 хувийг эздийн өмч, 56.1 хувийг өр төлбөр тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА хуулийн этгээдүүдийн нийт орлого 28,773,033.5 мянган төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 6.8 дахин өссөн бол нийт зардал 23,433,903.1 мянган төгрөгт хүрч мөн 3.2 дахин өссөн байна.

ҮМҮЧЭТХЭА хуулийн этгээдүүдийн цэвэр ашиг 5,339,130.4 мянган төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.8 дахин өссөн байна.



## Дүгнэлт

Тайлант хугацаанд 648 борлуулалтын мэдээ, 49 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдийн санхүүгийн тайланг хянан баталгаажуулж, салбарын нэгтгэлд хамруулав.

2022 оны эхний хагас жилд ҮМҮЧЭТХЭА эрхлэгч хуулийн этгээдүүдийн нийт зардал нийт орлогоос 1.7 дахин их байсан нь тус салбар (3,037,005.7) мянган төгрөгийн цэвэр алдагдалтай ажиллахад нөлөөлсөн бол тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгч хуулийн этгээдүүдийн нийт орлого нийт зардлаас 1.2 дахин их байгаа нь тус салбар 5,339,130.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллахад нөлөөлжээ.

Мөн тайлант хугацааны нийт орлого өмнөх оны мөн үеэс 6.8 дахин, нийт зардал 3.2 дахин, цэвэр ашиг 2.8 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хорооны 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 11/2011 тоот албан бичгээр нэр бүхий 211 үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэдэд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай мэдэгдлийг хүргүүлсэн.

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Хорооны 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар нэр бүхий 106 иргэний үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, нэр бүхий 8 иргэний ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.



# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.

2023 ОН